

Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр
авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан

2020 он 06 сар 16

Нийслэлийн Спортын хорооны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Нийслэл дэх Төрийн Аудитын газраас хийсэн аудитаар нийт 4172.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 4172.4 мянган төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн. Үүнд:

Тайлант оны нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг 3126.1 мянга, хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/-ын өглөгийг 1016.3 мянга төгрөгөөр тус тус дутуу бүртгэж тайлагнасан нь хэмжилт, үнэн зөв байдал, үнэлгээ эрх үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй, УСНББОУС-1 болон 19, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” заалттай нийцэхгүй байна.

Үүний дагуу 2019 оны санхүүгийн тайланд алдааг залруулж залруулга хийсэн.

Дараагийн аудитаар хянаж үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Татвар, нийгмийн даатгалын өглөгийг санхүүгийн тайланд толилуулдаггүй тул анхаарал татахуйц асуудлыг дараагийн аудитаар хянаж үзэх нь зүйтэй гэж үзсэн.

Шилэн дансны мэдээлэл:

Нийслэлийн Спортын хороо нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасны дагуу 6 дугаар зүйлийн 6.8.-д заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар болон shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Нийслэлийн Спортын хороо нь шилэн дансны нэгдсэн системд 2019 онд 139 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг байршуулаагүй байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6 заалт бүхий зөвлөмж өгснөөс 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай байна. Хөрөнгийн элэгдлийг дутуу байгуулсан 1414.2 мянган төгрөгийн зөвлөмж хэрэгжээгүй байна.

Дээрх алдаа, зөрчлүүдийг арилгуулахын тулд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах, үнэн зөв тайлагнах; нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомж, стандарт, дүрэм журамд нийцүүлэн шинэчилж байх; нягтлан бодох бүртгэлийн программд шаардлагатай шинэчлэлтийг хийлгүүлж байх талаар зөвлөмжүүдийг өгсөн.

Өгөгдсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Нийслэл дэх Төрийн аудитын газраас өгсөн зөвлөмжүүдийн дагуу холбогдох хууль тогтоомжийн заалтуудыг мөрдөн ажиллаж байна.

Татвар, нийгмийн даатгалын тайланг цаг хугацаанд нь үнэн зөв тооцож тайланг хугацаанд нь гарган холбогдох газарт нь нэгтгүүлэн ажиллаж байна.

Шилэн дансны тухай хууль тогтоомжийг мөрдөж, дутуу оруулсан байсан мэдээллийг бүрэн гүйцэд нөхөж оруулан 2020 онд шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв оруулан ажиллаж байгаа болно.

НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРОО